МАНАЙ СОНИНЫ I УЛИРЛЫН ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,123.214... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.12.27. Мягмар. №242 (4612) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

УЛС ТӨР

З.НАРАНТУЯА: ХӨГЖЛИЙН БАНКНЫ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛЫГ ФЕЙСБҮҮК ДЭЭР ТАВИНА

II нүүрт

УЛС ТӨР

Д.ОЮУНХОРОЛ: УЛААНБААТАРТ ТАРААГДСАН САЙЖРУУЛСАН ЗУУХНЫ 50 ХУВЬ НЬ АШИГЛАГДАХГҮЙ

IV нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




ҮЗЭЛ БОДОЛ



# УТААНААС БОЛЖ ЖИЛД 100-200 ХҮҮХЭД НАС БАРЖ БАЙНА, ЭНЭ ЗҮГЭЭР ҮҮ

Н.ПУНЦАГБОЛД

Улаанбаатар хотын агаарын бохирдол гамшгийн хэмжээнд тулаад өчнөөн жил боллоо. Монголчууд бид тэвчээртэй хүмүүс юм. Утаандаа хордоод л, зуухыг зуухаар сольж байхад хүлцэнгүй хандаад л. Угаасаа утаа байх ёстой юм шиг л санаж явсан. Харин энэ жил эцэг, эхчүүд тэвчихээ болиод, чих нь дүлийрээд удаж байгаа төр засгийнханд бага ч болов зүйлийг ойлгуулахын тулд өчигдөр жагслаа. Энд нэг тоо баримт дурьдая. Утааны эсрэг жагсаалд оролцож буй ээжүүдийн төлөөлөл О.Ундрам гэх бүсгүй сэтгэл хирдхийлгэм тоо баримтыг дурьджээ. Тухайлбал, жилдээ 40 мянган хүүхэд хатгалгаа тусдаг аж. Харин 2016 онд гэхэд улсын хэмжээнд уушгины хатгалгаагаар 0-1 насны 505 хүүхэд нас баржээ. Улсын хэмжээнд ч юу байх вэ дээ, Улаанбаатар хотод л байхгүй юу. Өнгөрсөн 2015 онд гэхэд 475 хүүхэд уушгины хатгалгаагаар нас барж байж. Арай л дэндсэн тоо биш үү. Монгол Улсыг онож төрснийхөө төлөө алгын чинээ нялх үрс ердөө л ганц жил орчлонг хараад буцаж байна. Бүр жилд 500-гаараа шүү дээ. Магадгүй заримд нь энэ хэтэрхий их тоо юм шиг санагдаж байж болох. Тэгвэл жил бүр 1-5 настай 100-200 хүүхэд уушгины хатгалгааны улмаас нас барж байна. Утаанаас болоод хүүхдэд дархлаа ч тогтож чадахгүй байна шүү дээ, үнэндээ.

*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

**Үргэлжлэл нь III нүүрт**

Дугаарын 60 мөр

## Олуул явсныхаа хэрээр мөнгө олоод ирдэг бол сайхан аа

Ч.ЧУЛУУН

УИХ-ын дарга М. Энхболд тэргүүтэй төлөөлөгчдийн булангийн орнуудад хийж буй айлчлал үргэлжилсээр. Айлчлалын талаархи мэдээлэл цахим ертөнцөд цаг алдалгүй тавигдсаар. Ямартай ч УИХ-ын дарга, МАН-ын дарга маань ямар ч тохиолдолд алзахааргүй олуулаа явaa юм байна. Хэвлэлийн албаных нь мэдээлэлд дурьдсанаар, түүнийг УИХ, Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Эрчим хүчний сайд П.Ганхүү, УИХ-ын гишүүн Н.Энхболд, Ж.Бат-Эрдэнэ, Г.Мөнхцэцэг, Б.Наранхүү, О.Содбилэг, Г.Тэмүүлэн нарын 11 хүн дагалдаж яваа аж. Лалын шашинтай оронд айлчилж байж гуя хасаа гарган суух эмэгтэйн нэр айлчлалын бүрэлдэхүүнд байгаагүйг бодоход түүн шиг хэн нэгний суганд хавчуулагдан нисч орхисон эрвээхий нэг биш хэд хэд байгаа бололтойдог. Тэд жирийн иргэдтэй холилдон зорчигчийн суудалд л тухлав гэж.

**Үргэлжлэл нь III нүүрт**




ОНЦЛОХ 10 ҮЙЛ ЯВДАЛ

## Ирэх 2017 онд болох 10 ТОМООХОН ҮЙЛ ЯВДАЛ

Б.ДАВААХҮҮ

Он солигдох мөч айсуй. 2016 он улиран одож, 2017 он гарах мөч ойртож буй энэ үед дэлхий дахинаа ямар үйл явдал болохыг сонирхуулахаар бэлдлээ. Ингэхдээ ирэх онд болох 10 томоохон үйл явдлын хуанлиг уншигчиддаа хүргэж байна.

**Үргэлжлэл нь VII нүүрт**




ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

## АШУҮИС-ийн оюутнууд сэтгэлзүйн үйлчилгээг үнэ төлбөргүй авна

Н.БАТЗАЯА

Жижигхэн хэрнээ тав тухтай, амар амгаланг мэдрүүлсэн өрөөнд хэн нэгэнтэй сэтгэлээ онгойтол ярьж суух ийм нэгэн агшин дэлхийн өндөр хөгжилтэй оронд ихээхэн таарна. Өөрөөр хэлбэл, хүн хоорондын харилцаа болон шийдвэр гаргахад, хүндрэл гарахад, стресс, сэтгэл санааны хямрал, гутрал, биеийн болон сэтгэлзүйн хүчирхийлэлд өртсөн, салалт, үхэл хагацал гэх мэт сэтгэл санаанд нь сөргөөр нөлөөлсөн үед тэр тохилог өрөөнд суух сэтгэлзүйчийг хүмүүс зорьж очдог. Харин тэд асуудалтай хүмүүст тодорхой сэтгэлзүйн техник, сэтгэл заслын тодорхой аргуудаас хэрэглэн үйлчлүүлэгчийн асуудлыг шийдвэрлэхэд нь тусладаг. Ийм арга барил өнөөгийн Монголын нийгэмд ихээхэн дутагдаж байгаа хоосон орон зай. Тэр дундаа их, дээд сургуулиудад сэтгэлзүйч гэх том орон зай хоосон ханхайж буй. Учир нь их, дээд сургуульд элсэн суралцаж буй оюутнууд дөнгөж сурагчийн ширээнээс босч, аливаад өөрийнхөө үзэл бодлоор хандаж, бие даан шийдвэр гаргахад хүрдэг. Шинэ орчин, шинэ найз нөхөд, шинэ хичээл, шинэ багш нар гээд шинэ бүхэнд дасах гэснээс болж нэлээд сэтгэлзүйн дарамтад ордог байна. Үүнээс болж гэрээ санах, хичээлдээ муудах зэрэг сөрөг үр дагаварууд гардаг. Харин энэ хоосон орон зайг дүүргэсэн нэгэн үйл явдал өчигдөр боллоо. тодруулбал, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн “Сэтгэлзүйн зөвлөгөө өгөх төв”-ийн нээлт болсон юм. Нээлтэд тус сургуулийн захирал Г.Батбаатар болон сургуулийн удирдлага, оюутнууд оролцов.

**Үргэлжлэл нь VII нүүрт**

**ХААН банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2486.00 | 2496.00 | ФУНТ | 3002.00 | 3106.00 |
| ЕВРО | 2563.00 | 2634.00 | РУБЛЬ | 39.00 | 42.30 |
| ИЕН | 21.02 | 21.37 | ЮАНЬ | 357.00 | 359.90 |

**Худалдаа хөгжлийн банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2482.00 | 2496.00 | ФУНТ | 3019.00 | 3110.00 |
| ЕВРО | 2566.00 | 2646.00 | РУБЛЬ | 39.62 | 42.62 |
| ИЕН | 20.97 | 21.62 | ЮАНЬ | 356.50 | 360.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР





## Д.ХАЯНХЯРВАА: ХӨГЖЛИЙН БАНКНЫ ШАЛГАЛТЫН ДҮНГ НУУЦЫН ЗЭРЭГЛЭЛЭЭС ГАРГАНА

Ж.ОТГОН

УИХ дахь МАН-ын бүлэг Хөгжлийн банкны тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулга, мөн тус банкны шалгалтын дүнтэй холбоотой асуудлаар хэлэлцлээ. Түүнчлэн сүүлийн үед хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч байгаа Тавантолгойн төсөлтэй холбоотой асуудлаар Засгийн газрын гишүүдээс тодорхой мэдээлэл авсан. Үүнээс бүлгийн гишүүд Хөгжлийн банкны шалгалттай холбоотой асуудлаар түлхүү санал бодлоо солилцов. Учир нь, Хөгжлийн банкны шалгалттай холбоотой 200 гаруй хуудас баримтыг өнгөрсөн баасан гарагийн УИХ-ын чуулганы хуралдаан тарах үеэр Засгийн газраас УИХ дахь МАН-ын бүлэгт нууцын зэрэглэлтэйгээр ирүүлсэн байна. Хэлэлцсэн асуудлын талаар бүлгийн дарга Д.Хаянхярваа “Өнөөдөр бүлгийн хурлаар Хөгжлийн банкны хуулийн шинэчилсэн найруулга болон шалгалтын дүнтэй холбоотой асуудлаар санал солилцлоо. Мөн Тавантолгой төсөлтэй холбоотой мэдээллээр Засгийн газрынхныг дуудаж, тодорхой мэдээлэл авлаа. Хөгжлийн банкны шалгалтын дүн болох 200 гаруй хуудас материалыг өнгөрөгч Баасан гарагийн УИХ-ын чуулганы хуралдаан тарахын өмнө Засгийн газраас манай бүлэг дээр нууцын зэрэглэлтэйгээр ирүүлсэн. Нууцын зэрэглэлтэй материалыг аваад шууд чуулганы танхимаас цацаж байгаа нь хууль зөрчиж байна гэж сая бүлэг дээр үзсэн. Өөрөөр хэлбэл, Хөгжлийн банктай холбоотой нууцын зэрэглэлтэй материалыг нууцын зэрэглэлээс гаргахын тулд тусгай процедуртай байдаг. Бүлэг дээр нэгэнт олон түмэнд ил цацсан болохоор холбогдох байгууллагад хандаад нууцын зэрэглэлээс гаргаж тавь гэж байгаа. Ингээд Хөгжлийн банкаар дамжсан төсөл, хөтөлбөрүүд хуулийн дагуу явагдсан уу гэдгийг эхний ээлжинд тогтоох ажлын хэсгийг Ж.Энхбаяр гишүүнээр ахлуулж байгуулсан. Өнөөгийн мөрдөж байгаа хуулийн дагуу төсөл, хөтөлбөрүүд явагдсан уу гэдгийг энэ ажлын хэсэг ил гаргаж тавья гэж байгаа. АН-ынхан “Монполимет” болон “МАК”-ийн авсан зээлүүдийг голлож МАН-ынхан авсан гэж яриад байгаа. Сонгуулийн өмнө Ерөнхий сайд асан Ч.Сайханбилэг дээрх хоёр үйлдвэрийн нээлтэд очиж, тууз хайчлаад, “Хөгжлийн банкнаас олгосон хамгийн үр ашигтай төсөл энэ боллоо” гэж байсан. Тиймээс энэ мэдээлэл үнэн үү, худлаа юу гэдгийг ил гаргаж тавих ёстой гэдэг үүднээс энэ асуудлыг ярьсан” гэлээ. Тавантолгой төслийн тухайд сүүлийн үед Тавантолгойн ордын 49 хувийг 400 сая ам.доллараар зарна гэх мэдээлэл цацагдаад байгаа. Энэ талаар тэрбээр “Бид хэвлэл мэдээллийн хэрэгслээр гараад буй Тавантолгойн төсөлтэй холбоотой асуудлаар Засгийн газрын гишүүдээс мэдээлэл авлаа. Мөн Тавантолгойн хувьд 49 хувийг 400 сая ам.доллараар зарах уу, төсөл хөтөлбөрийг бэлэн болгоод үзээглэх гээд байгаа юм уу гэдэг асуудлыг Засгийн газраас асууж тодруулсан. Харин Ерөнхий сайд, Уул уурхайн сайдын зүгээс Тавантолгойн төсөл зөвхөн эхлэлийн шатандаа л явж байна гэдэг хариултыг өглөө. Гадна дотны компаниуддаа саналаа өгчихсөн, өөрсдийн санал, нөхцлөө хэлж, илэрхийлж байгаа юм байна. Түүнээс биш 49 хувийг 400 сая доллараар зарах гээд байгаа зүйл огт байхгүй гэсэн. Эцсийн байдаар 66 хувь нь ММС, 34 хувь нь Засгийн газар, 49 хувь нь Шиньхуа байна гээд тохиролцоод гэрээ хэлэлцээр хийж гарын үсэг зурсан зүйл байхгүй. Ер нь 49/51 гэдэг бол зөвхөн Засгийн газрын түвшинд яригдаж байгаа нэг л хувилбар. Тавантолгой Оюутолгойн замаар ороод алга болчих юм байна гэдэг хардлагууд байгаа бол тийм биш юм. Учир нь Засгийн газраас бүх ажлыг хуулийн дагуу явуулна гэж хэлж байгаа. Монголд хамгийн үр ашигтай байх хувилбарыг сонгоод УИХ-д өргөн барьж хэлэлцүүлнэ гэж Засгийн газраас мэдэгдсэн. Түүнээс биш өөр хувилбар гаргаад бие даан шийдвэр гаргах хууль эрх зүйн орчин байхгүй. Бид ч тийм зарчмаар явуулахгүй” гэлээ.


MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс:
976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.


МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## "Хуулийн зардлыг олон улсын байгууллагад тулгуурлан шийднэ"

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох хуулийн төслүүдийг УИХ-ын чуулганы хуралдаанаар батласан билээ. Тэгвэл уг асуудлаар УИХ-ын гишүүн Х.Нямбаатар, М.Оюунчимэг, Н.Оюундарь нар хэвлэлийн бага хурал хийлээ. УИХ-ын гишүүн Н.Оюундарь “Уг хуулийн төслийг батлуулах ажлын хэсэг УИХ-ын гишүүн Л.Цогзолмаа, М.Оюунчимэг А.Ундраа, Х.Нямбаатар, Д.Цогтбаатар, Б.Пүрэвдорж нарын өргөн бүрэлдэхүүнээр ажиллаж, гурван сарын хугацаанд хууль тогтоомжтой танилцлаа. Түүнчлэн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр ажилладаг гадаад дотоодын олон улсын байгууллага, Төрийн бус байгууллага, судлаачтай уулзах, цаашлаад түр хамгаалалтын байруудаар явж газар дээр нь биечлэн танилцсан юм. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль хэд хэдэн онцлогтой болсон. Тухайлбал, уг хуулиар эхнэр нөхөр, үр хүүхдийн хоорондын харилцааг зохицуулах төдий бус хамтран амьдрагчид, салсан гэр бүлийн асуудлыг ч хөндөж хамрах хүрээг нь өргөжүүлсэн. Түүнчлэн гэр бүлийн хүчирхийллийн талаархи мэдээллийн сувгуудыг тэлэх, тэр дундаа хөршийн үүргийг тодорхойлж, удаа дараагийн гэмт үйлдлийг мэдээлээгүй айл хөршид хариуцлага тооцохоор болсон. Цаашлаад гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, хамтарсан баг хэрхэн ажиллах бүх зохицуулалтыг тодорхой болгосон” гэдгийг онцолж байлаа. Харин УИХ-ын гишүүн Х.Нямбаатар “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийг хэрэгжүүлэхийн тулд захиргааны байгууллагууд итгүүлэх, албадах аргыг хэрэглэнэ. Хууль сурталчлаад, энэ талаар сургалт мэдээлэл явуулаад байхад зөрчил гаргасан анхны тохиолдолд захиргааны хариуцлага хүлээлгэнэ. Харин удаа дараагийн үйлдэл гаргавал үүнийг гэмт хэрэг гэж үзэн албадах буюу холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Мөн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль хэрэгжиж эхлэхээр холбогдох эдийн засгийн зардлыг 2017 оны улсын төсөвт суулгаагаагүй ч, олон улсын байгууллага, дотоод нөөц боломжид тулгуурлан шийдэхээр болсон” гэлээ.

## З.НАРАНТУЯА: ХӨГЖЛИЙН БАНКНЫ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛЫГ ФЕЙСБҮҮК ДЭЭР ТАВИНА

УИХ дахь АН-ын бүлэг ээлжит хуралдаанаа хийж, хурлаар хэлэлцсэн асуудлыг талаар бүлгийн дэд дарга Б.Пүрэвдорж болон УИХ-ын гишүүн З.Нарантуяа, Л.Болд нар мэдээлэл хийлээ. Бүлгийн хуралдаанаар энэ долоо хоногт хэлэлцэх Хөгжлийн банкны тухай хуулийн төсөл болон Хөгжлийн банкинд хийсэн шалгалтын талаар хэлэлцжээ. Бүлгийн дэд дарга Б.Пүрэвдорж “Чингис, Самурай бондоор нийт 1.8 тэрбум ам.доллар 580 саяын евро бонд босгож Хөгжлийн банкаар дамжуулан төсөл хөтөлбөрүүдэд олгосон. Энэ гадаад бондоор маш их хэрэгцээгүй зүйл хийж, идэж уусан гэж МАН-ынхан улстөржсөн. Хөгжлийн банкинд шалгалт хийсэн ажлын хэсгийн 200 гаруй хуудас дүгнэлт нууц байсныг өнгөрсөн долоо хоногт манай бүлгийн гишүүд авч танилцсан. Ажлын хэсгийн дүгнэлтээс харахад, Хөгжлийн банкны нийт зээлийн 50 хувийг улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцлөөр бүтээн байгуулалтын 389 төсөл хөтөлбөрт олгосон. Тэр төсөл хөтөлбөрийн жагсаалтыг олон нийтэд ил болгох хэрэгтэй. 25 хувийг нь арилжааны банкаар дамжуулан 2000 орчим компанид зээл олгосон. Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй болон арилжааны банкуудаар дамжуулан олгосон зээлд зээлийн эрсдлийн сан байгуулаагүй. Тэгэхээр нийт зээлийн 75 хувь нь асуудалгүй. Үлдсэн 25 хувийг Хөгжлийн банк 16 төсөл хөтөлбөрт зээл олгосон. Нийт зээлийн дөрвөн хувь дээр нь эрсдэлийн сан байгуулсан байна. Эрсдэлийн сан байгуулсан компаниудын ихэнх нь төрийн өмчийн компани байгаа юм. Тодруулбал, Дулааны цахилгаан станц, Амгалан станц, МИАТ, “Эрдэнэс MGL”, “Эрдэнэс Тавантолгой”, ТОСК зэрэг томоохон төрийн өмчийн компани энэ зээлийн ихэнхийг нь авсан. Энэ зээлүүд дээр эрсдэлийн сан байгуулсан” гэлээ.

Хувийн хэвшлийн компаниуд дунд МАН-ын гишүүдтэй холбоотой компани байна гэсэн дүгнэлтэд хүрсэн. АН-ын бүлэг шалгалтын дүнгийн 200 хуудас материалыг олон нийтэд нээлттэй болгох шаардлага тавьсан. Энэ шаардлагыг Засгийн газар биелүүлнэ гэж амласан. Мөн түүнчлэн Хөгжлийн банкны тухай хуулийг хурдан шуурхай хэлэлцэж улстөрчдөөс хараат бус байх боломжоор хангахаар болсон. Энэ долоо хоногт хуулийн төслийг хэлэлцүүлэхээр болсон. Энэ талаар УИХ-ын гишүүн З.Нарантуяа “Энэ долоо хоногийн УИХ-ын хэлэлцэх асуудлын жагсаалтад Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэхээр болсон. Миний бие хуулийн төслийг хамтарч боловсруулсан. Хөгжлийн банктай холбоотой асуудалд цэг тавьж мухарлах хэрэгтэй байгаа юм. Тус банк нь Монгол Улсын эдийн засгийг урт хугацаанд өргөх том төслийг санхүүжүүлэх, гадны хөрөнгө оруулалтыг татах хамгийн том институц юм. Энэ институцийг бид улстөржүүлээд хаячихвал үнэ цэнэ нь буурна. Гадаад зах зээл дээр Хөгжлийн банкны бонд эрсдэлд орно. Тиймээс тус банкны үнэ цэнийг хамгаалж, үүрэг чиглэлийнхээ дагуу ажиллах боломжоор хангах нь зүйтэй. Бид өнгөрсөн хугацаанд Хөгжлийн банкаар дамжуулж олгосон нийт зээлийн 54 хувийг Монгол Улсын эдийн засгийг дэмжихэд зарцуулсан. Ялангуяа эдийн засгаа солонгоруулах, ажлын байр нэмэгдүүлэх, бүтээн байгуулалтын ажилд зарцуулагдсан. Энэ бүгдийг хувийн сектор хийсэн. Хувийн салбараа дэмжих ажил орлоготой болгохын тулд бонд гаргасан. Үүнийг зүгээр л үр ашиггүй өр гэж нэг талаас нь тайлбарлах зохимжгүй. Тиймээс тоон дээр суурилж дүгнэлт гаргахыг хичээсэн. Яг өнөөдрийн байдлаар “Чингис” бондын 2.6 их наяд төгрөгийн зээл байна. Засгийн газар Хөгжлийн банкны шалгалтыг актыг нууцын зэрэглэлээс ил гаргасны дараа шалгалтын материалыг фейсбүүк дээр тавина. Төсөл хэрэгжүүлсэн компаниуд төсөвт өртгөө нэмэгдүүлсэн гэж буруутгах нь зохимжгүй. Зарим нэг алдаатай зүйл байгаа байх. Хууль хяналтын байгууллага үнэн зөвөөр нь тогтоогоод өөрсдийн шугамаар ажлаа хийдэг баймаар байна. Тэр болгоныг улстөржүүлж, иргэдийг төөрөгдүүлсэн мэдээлэл өгөхгүй байх хэрэгтэй. Тиймээс шинэчилсэн найруулгын төсөлд хэд хэдэн зарчмын өөрчлөлт хийхгүй бол болохгүй юм байна гэж үзсэн. Нэгдүгээрт, Хөгжлийн банкаар дамжуулж хэрэгжих Монгол Улсын хөгжлийн бодлого, урт хугацааны баримт бичгүүдтэй уялдуулж, төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл нь Хөгжлийн банкны нийт санхүүжилтийн хэдэн хувь нь байх юм бэ гэдгээ тодорхой тогтоож журам стандартаа тодорхой болгож өгөх хэрэгтэй байгаа юм. Хоёрдугаарт, Хөгжлийн банкинд бие дааж ажиллах боломжийг олгож өгөхгүй бол бүх зүйл улс төрөөс хамааралтай, хараат бус, бие дааж ажиллах чадваргүй болчихоод байна. Тийм чадвартай болгохын тулд эрх, үүргийг нь өргөн болгож өгөх хэрэгтэй. Өнөөдөр тус банкны ТУЗ-ийн есөн гишүүний зургааг Засгийн газраас томилж байна. Тэгэхээр Хөгжлийн банкны ТУЗ улс төрөөс хараат, тэр тусмаа Засгийн газар төрийн албан хаагчдаа тийш нь томилох нь утгагүй зүйл. Энэ цэвэр мэргэжлийн хүмүүсийг тавьдаг байх ёстой гэж хуулинд оруулж өгч байгаа” гэв.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

## ШИНЭЭР ЭЛССЭН ГИШҮҮД НАМЫН ДАРГЫН СОНГУУЛЬД САНАЛ ӨГӨХ ЭРХТЭЙ ГЭВ

АН-ын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Л.Эрхэмбаяр намын даргын сонгуультай холбогдуулан мэдээлэл хийлээ. Тэрбээр “АН-ын даргын сонгуульд оролцох намын гишүүдийн бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой Ардчилсан намын даргын тушаал гарсан. Энэ тушаал нь орон нутгийн гишүүдийн санал дээр үндэслэж, орон нутгийн байгууллагуудын саналыг авч АН-ын даргад нэр дэвшиж байгаа нэр дэвшигчдийн саналыг авсны үндсэн дээр намын батлахаа гээгдүүлсэн болон АН-д гишүүнээр элсэх бүртгэх үйл ажиллагааг орон даяар өнөөдрөөс /өчигдөр/ эхлэн явуулж байна. АН-ын шинэчилсэн бүртгэлийн ажиллагаа энэ сарын 08-наас эхлээд явагдсан. Энэ үйл ажиллагаанд батлахаа гээгдүүлсэн болон шинээр элсэх хүсэлтэй хүмүүсийг бүртгээгүй байсан. Одоогоор орон нутагт цас зудтай байгаа учир шинэчилсэн бүртгэлийн явц удаашралтай байгаа. Шинэчилсэн бүртгэл ирэх сарын 06-ныг хүртэл үргэлжилнэ” гэлээ. Түүнчлэн “2000 онд таван нам нийлэх үед батлахаа аваагүй, одоо авах хүсэлтэй байгаа хүмүүсийг бүртгэж, АН-ын даргын сонгуульд санал өгөх эрхээр нь хангах эрхзүйн үндсийг хангаж өгсөн АН-ын даргын тушаал гарсан. Тийм учраас өнөөдрөөс эхлэн шинээр элсэх хүсэлтэй болон батлахаа гээгдүүлсэн иргэд өөр, өөрийн харьяаллын орон нутгийн намууд дээр очиж шинэчилсэн бүртгэлд хамрагдаарай” гэдгийг дуулгав. Ардчилсан намын даргын сунгаанд Н.Алтанхуяг, Д.Эрдэнэбат, Л.Гантөмөр, Ж.Батзандан, С.Эрдэнэ нарын таван хүн өрсөлдөж байгаа бөгөөд өнгөрсөн долоо хоногт Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Дорноговь, Говьсүмбэрзэрэгаймагтажиллаж, гишүүд дэмжигчидтэйгээ уулзан мөрийн хөтөлбөрөө танилцуулсан. Өчигдөр Төв аймгийн АН-ын гишүүд дэмжигчидтэй уулзаж, мөрийн хөтөлбөрөө танилцуулжээ. АН-ын даргад нэр дэвшигчдийн хувьд Сонгуулийн хорооноос баталсан дотоод журмын дагуу уулзалт, сурталчилгаагаа хийж байгаа юм. Тухайлбал, нэг нэр дэвшигч сурталчилгаандаа хоёроос илүү машин авч явахгүй, 00.00 цагаас хойш хүнтэй уулзахгүй, орон нутагт албан ёсоор штаб байгуулахгүй, тус, тусдаа сурталчилгаа хийхгүй байх зэрэг хатуу журмаар зохицуулсан байна.

# УТААНААС БОЛЖ ЖИЛД 100-200 ХҮҮХЭД НАС БАРЖ БАЙНА, ЭНЭ ЗҮГЭЭР ҮҮ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Гэтэл төр засгийнхан утааг бууруулахад чиглэсэн ямар ажил хийсэн билээ өнгөрсөн жилүүдэд. Огт ажил хийгээгүй гэж хэлэхэд хэцүү л дээ. Тэд түлшний хэмнэлттэй зуух тараасан. Утаагүй түлш үйлдвэрлэх гэж оролдсон. Гэр хорооллыг орон сууцжуулах гэж хичээсэн. Гэвч үр дүн гарсан бил үү, үгүй. Харин ч жилээс жилд утааны хэмжээ, хор нэмэгдсээр байна. Аргагүй шүү дээ, нийслэлийн гэр хороолол жилд дунджаар 5000 айлаар нэмэгдэж, тэр хэмжээний яндан утаа үйлдвэрлэж байхад буурахгүй нь тодорхой. Харин нөгөө талдаа гэр хорооллоос хэчнээн айл нүүж, орон сууцанд орсон билээ. Ипотекийн зээл яг байгаа оносон бил үү. Нэг орон сууцтай нь хоёртой болж, бага талбайтай байшинтай нь томосгосон л байх. Гэтэл улсны төсвөөс 2011-2015 он хүртэл нийтдээ 135 тэрбум төгрөг утааны эсрэг “дайн”-д зарцуулжээ. Харамсалтай нь энэ “дайн”-д ялалт байгуулсангүй. Энэ мөнгө бол ердөө хэдхэн жилийн хугацаанд зарцуулсан 100 хол давсан тэрбум төгрөг шүү дээ. Гэтэл өчигдөр утааны эсрэг жагсаалд оролцсон хүмүүсийн өгсөн мэдээллээр бол / гэхдээ албан бус мэдээлэл/ утааг арилгахад “Цэвэр агаар” сангаас 93.2, Засгийн газраас 70, Мянган сорилтын сангаас 50 тэрбум төгрөг үрэн таран хийж. Нийтдээ өнөөдрийн хүртэл 213.2 тэрбумыг зарцуулсан. Үүний үр дүнд утааны хэмжээ улам нэмэгдэж, Монголын ирээдүй болсон мянга мянган үрс ханиад томуунд дарлуулж, хэвтэх ч эмнэлэггүй гэртээ халуурч хэвтэнэ. Өнгөрсөн хугацаанд бид энэ их мөнгөөр чухамдаа юу хийлээ. “Утаагүй” зуух тараасныг эс тооцвол тэр гээд хэлчих дорвитой ажил бараг л хийгээгүй. Яах вэ, хуруу дараад тооцвол хийсэн ажил бий бий. Гэхдээ л хамгийн их өргөн хүрээг хамарсан ажил нь “утаагүй” зуух тараах байлаа. Яах вэ, эхний ээлжинд хийж хэрэгжүүлэх ёстой л ажил байсан болов уу. Харамсалтай нь зуухаа тараачихаад, дараа нь хяналт тавьсан бил үү. Өнөөдөр нийслэлийн гэр хорооллын 200-гаад мянган айлд бүгдэд нь шахуу зуух тараасан. Тэгвэл одоо яваад, шалгаад үзвэл тэдний хэд нь өнөөх зуухаа ашиглаж байгаа бол. Талаас илүү хувь нь хөдөө явчихсан байгаа даа. Өнөө хүртэл үе үеийн Засгийн газрынхны хийсэн ажил нэг иймэрхүү л маягтай байгаа. Ийм байхад яаж утаа буурах вэ дээ. Хэрвээ үүнийхээ оронд аль хэдийнэ хэдэн цахилгаан станцаа өртгөтгөөд, чадлыг нь нэмээд, гэр хорооллын иргэдийн цахилгааны төлбөрийн шөнийн тарифыг тэглээд явж байсан бол арай өөр байх байлаа. Шөнийн тарифаа тэглээд, нүүрс түлэхийг хориглох талаар ч судалж байсан бол асуудал арай өөр байх байсан. Бүр тэгж ярьвал өнөөдрийг хүртэл үрэн таран хийсэн 213.2 тэрбумаараа орон сууц бариад, иргэддээ 50 хувийн хөнгөлөлттэй оруулчихсан бол 15 мянган айлын яндан хасагдах байсан. Хар ухаанаар тооцоход шүү дээ. Харамсалтай нь төр засгийнхан тэгсэнгүй, утааны эсрэг тэмцсэн дүр үзүүлээд, заримыг өөрсдийнхөө халаасанд хийгээд, ганц хоёр хүнд ял оноосон болоод л дууссан. Харин эцэг, эхчүүд утааны эсрэг жагсана, тэмцэнэ гэхээр л Ерөнхий сайд нь мэдээлэл хийж, ирэх оны эхнээс гэр хорооллын цахилгааны шөнийн тарифыг тэглэх асуудлыг ярилаа. Оройтож гарч байгаа ч хамгийн зөв алхам. Гэхдээ зүгээр л шөнийн тарифыг тэглэлээ гээд бүх зүйл шийдэгдчихгүй. Цаашлаад гэр хорооллыг цахилгаанаар халаадаг болох асуудлыг шийдэх хэрэгтэй. Ядаж л гуравны нэг нь халаалтаа цахилгаанаар шийдчихвэл утааны асуудал бага ч гэсэн шийдэгдэнэ. Үндсэндээ одоо байгаа утаа гурав дахин буурна гэсэн үг. Энэ бол ойрын 2-3 жилийн дотор яаралтай авч хэрэгжүүлэх арга хэмжээ. Тэр гэр хорооллыг орон сууцжуулаад, эсвэл төвийн шугамд холбоод утаанаас салах “үлгэр” бол удаан яригдах асуудал. Тиймээс цахилгаан станцуудын хүчин чадлыг нэмэх, гэр хорооллын айл өрхөд цахилгаан халаалтын орчин үеийн техник технологийг хямдралтай үнээр худалдах асуудлыг ч шийдэх шаардлагатай байна. Тэгэхгүй бол бид гамшгийн бүсэд амьдарч, бүх нийтээрээ хордож дууслаа. Монгол Улс ердөө л гуравхан сая хүнтэй. Түүнийх нь тал нь Улаанбаатар хотод, утааны бүсэд, аюултай, хортой орчинд амьдарч байна. Өнөөдөр ямар нэг өвчлөлөөр нас барж байгаа бүх хүний бурханы орныг зорьж байгаа шалтгааныг утаа гээд хэлчихэд нэг их буруудахгүй. Тийм болохоор эрх баригчид, засаг төрийнхөн утааны эсрэг тэмцэх мөнгө хөрөнгөө амин хувьдаа авч ашиглахгүй баймаар байна. Дээрээс нь зөв зүйлийн төлөөх тэмцэлд арай ахиухан мөнгө зарцуулах хэрэгтэй шүү дээ. 2017 онд утаатай тэмцэхэд зориулж дөрөвхөн тэрбум төгрөг төсөвлөсөн. Гэтэл үүнээс өөр хэрэгтэй, хэрэггүй хөтөлбөрт 10 дахин их мөнгө төсөвлөөд л байж байна. Хэрвээ бид утаанаасаа салахгүй бол хэчнээн сайхан тохилог, өнгө үзэмжтэй, өндөр барилгатай, шил толь болсон Улаанбаатарт амьдраад яах вэ дээ.

Дугаарын 60 мөр

## Олуул явсныхаа хэрээр мөнгө олоод ирдэг бол сайхан аа

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Тусгай суудалд залран, тусгай үйлчилгээг хүсэмжлэх нь мэдээж. Тэр тоолонгоор татвар төлөгчийн мөнгө урсч буй.

Улсын эдийн засаг хямарч, төсвийн байгууллагынхан цалингаа тавьж чадахгүй, Засгийн газар нь хэмнэлт хэмээн “бахирч” хуруу хумсаа хуйхалж байхад олуул онгоц хөлөглөн тансаглаж яваа нь ард түмэнд таалагдахгүй байна. Хэдий чинээ олуул явна, тэр чинээгээр мөнгө олоод ирдэг юм бол би ч гэсэн тэр айлчлалд багтчихмаар байна шүү дээ. Салбарын асуудлыг зангидаж, бодлого хэрэгжүүлдгийн тухайд Засгийн газрын хоёр гишүүний хувьд байж болно. Харин УИХ-ын гишүүдийн тухайд эсгий хийх газар нохой хэрэггүй баймаар. Хоёр улсын гадаад харилцаа, хамтын ажиллагаанд Б.Наранхүү, Г.Мөнхцэцэг нарын дипломат харилцааны “А”-гийн ацаггүй нөхдүүд ямар үүрэг гүйцэтгэх юм. Шулуухан хэлэхэд, боломжийг ашиглаад төрийн мөнгөөр зугаалж л яваа байхгүй юу. Эх орон, ард түмнээ гэсэн сэтгэлтэйсэн бол мөнгө үрсэн айлчлалаас татгалзан, халаасан дахь мөнгөөрөө эхнэр, хүүхдээ дагуулаад явж байгаа бол Дубайдаа очиж тансаглана уу, Кувейтийн брэнд бараагаа бөөндөнө үү, хэнд хамаатай юм. Гагцхүү улс орон ядарч, элгээрээ хэвтэх шахаад байхад төр түшилцэж яваа эрхмүүд улсын халаасыг нимгэлж байгаад нь дургүй хүрээд байна. Эсвэл эрхэм төрийн түшээд маань хорт утаанаас хэд хоног болов зайлж, уушгиа цэвэрлэх гэсэндээ УИХ-ын даргыг хормойдчихсон хэрэг үү. Нөгөөтэйгүүр, УИХ-ын даргын ОХУ болоод Саудын Арабт хийж буй албан ёсны айлчлалын үр дүн нь юу байх юм. Монгол Улсын тавьсан санал бүхэнд л судална, судалгааныхаа багийг илгээнэ гэж хариулснаас харахад, шалихгүй болчтойдог шүү.

УИХ-ын хэвлэл мэдээллийн албанаас ирүүлсэн мэдээллээс харахад, Монгол Улсын УИХ-ын болоод МАН-ын даргыг хүлээн авч буй цаад тал гэхэд гурав эсвэл таван хүн зогсч байхад манайхан гурвын өмнөөс арван хэдүүл зогсч байх жишээний. Цаад тал айлчлалын бүрэлдэхүүнд ийм олон хүн байна гэж санаагүй юм уу, хоёр гурванхан ширээ тавьчихсан түүнд нь манай хэд чихэлдээд суунцгааж байх юм. Манай төрийн түшээд болоогүй л байна даа. Хэзээ юм үзэж нүд тайлсан улс шиг айлчлалын сургаар дэвхцэж гүйхээ болих юм бол доо.






# УЛС ТӨР

## Д.ОЮУНХОРОЛ: УЛААНБААТАРТ ТАРААГДСАН САЙЖРУУЛСАН ЗУУХНЫ 50 ХУВЬ НЬ АШИГЛАГДАХГҮЙ



Ж.ӨӨДЛӨН

УИХ-ын өргөдлийн байнгын хорооны хуралдаанаар “Агаарын бохирдол ба Улаанбаатарын утаа” сэдэвт хэлэлцүүлгийг хийлээ. Хэлэлцүүлгийн үеэр БОАЖ-ын сайд Д.Оюунхорол уг хуралдаанд мэдээлэл хийлээ. Тэрбээр “Агаар бохирдуулагч гол бодис PM10 тоосонцрыг 2016 оны арваннэгдүгээр сарын байдлаар нийт 11 цэгт 312 удаа тодорхойлоход 220 удаад нь буюу 71 хувьд нь стандартаас давсан байна. Харин PM2.5 тоосонцрыг арваннэгдүгээр сард нийт зургаан цэгт 167 удаа тодорхойлоход 147 удаад нь буюу 88 хувьд нь стандартаас давжээ. Азотын давхар исэл, хүхэрлэг хийн агууламж ч өндөр гарч байна. Улаанбаатар хотын агаарын бохирдлын эх үүсвэр болох түүхий нүүрсний хэрэглээ жилд 5.9 сая тонн бөгөөд үүнээс гэр хороололд 10 хувийг нь хэрэглэж байгаа боловч агаарт ялгаруулж байгаа бохирдлын 80 хувийг эзэлж байгаа. Харин цахилгаан станцад түүхий нүүрсний 85 хувийг нь хэрэглэж байгаа ч агаарт ялгаруулж байгаа бохирдлын хувь хэмжээний зургаан хувийг эзэлж байгаа нь өндөр яндантай, утаа хол хаягддагтай холбоотой байгаа юм. Улаанбаатар хотод 2016 онд 439 мянга гаруй тээврийн хэрэгсэл тоологдсон бөгөөд эдгээр автомашин агаарын бохирдлын хувь хэмжээний 10 хувийг эзэлж байна. Ялангуяа түгжрэлд зогсч байгаа автомашин тормос гишгэх үедээ агаарбохирдуулагчхүндметалыг ихээр ялгаруулдаг” гэдгийг салбарын сайд мэдээлэлдээ дурдлаа. Мөн тэрбээр “2011 оноос өнөөдрийг хүртэл олон улсын хамтын ажиллагааны төслүүдийн үнийн хөнгөлөлт, “Цэвэр агаар сан”-гийн татаастай үнээр Улаанбаатар хотод 175 мянга 618 сайжруулсан зуух тараасан тухай БОАЖ-ын сайд мэдээлэлдээ дурдав. “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын 2015 оны нэгдсэн тоо, бүртгэл”-ийн дүнгээр нийслэлийн төвийн зургаан дүүрэгт 161 мянган зуух бүртгэгдсэн байна. Үүнээс 38 хувь буюу 61 мянга нь энгийн зуух, 62 хувь буюу 100 мянга өрх нь сайжруулсан зуух ашиглаж байна. Энэ тооллогын дүнгээс харахад, Улаанбаатар хотод тараагдсан сайжруулсан зуухны бараг 50 хувь нь ашиглагдахгүй байгаа. Түүнчлэн өнөөдөр Улаанбаатар хотын гэр хороололд амьдарч буй 198 мянган өрхийн 30 хувь нь амьдралын нөхцөл боломж муугаас хуучин дугуй шатаах, ашигласан тээврийн хэрэгслийн тосонд тоосго дүрч шатаах, хог хаягдал түлж байгаа судалгааг гаргасан байна. Иймд дээрх түүхий нүүрсээ авч түлж чадахгүй байгаа иргэдийг халамжийн бодлогоор хяналттай зөв механизмаар сайжруулсан зуух болон түлшээр хангах ажлыг зохион байгуулах шаардлагатай байгаа” гэлээ.

### Агаарын бохирдлын төлбөр улсын төсөвт орох нь зөв үү

Уг нь агаарын бохирдлыг бууруулах чиглэлд агаар бохирдлын төлбөрийг бүрэн зарцуулж чаддаг бол асуудал арай өөр байх байсан биз. Гэтэл тэр мөнгө өөр зүйлд зарцуулагдаж байгааг гэдэг нь нууц биш. Уг нь Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд заасанаар олборлосон нүүрсний нэг кг тутамд нэг төгрөг, импортлосон, үйлдвэрлэсэн органик уусгагчийн нэг кг тутамд 10 төгрөг, автомашины ангиллаас хамаарч жилд 1800-9500 төгрөг татвар хураах зохицуулалттай байдаг. Дээрх төлбөрөөс жилдээ 30 орчим тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрдөг гэнэ. Гэвч агаарын бохирдлын төлбөр улсын төсөвт орж, зориулалтаараа зарцуулагдахгүй байгаа нь хуулийн амин сүнс болсон хэрэгжүүлэх механизм хангалтгүйбайгаагхаруулжбайна гэдгийг салбарын сайд нь онцолж байсан. Энэ талаар БОАЖ-ын сайд Д.Оюунхорол “Байгаль орчны хяналтын тогтолцоо нь Байгаль орчны яамнаас тусдаа мэргэжлийн хяналтын байгууллагаар хэрэгжиж байгаа нь тогтолцооны хувьд буруу байгаа юм. Энэ бол бодлого, хяналт хоёр уялдахгүй байгаагийн нэг илрэл” гэсэн юм. Мөн тэрбээр “УИХ, Засгийн газар агаарын бохирдлыг бууруулах асуудалд анхаарлаа хандуулан ажиллаж олон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсээр байгаа. Тухайлбал, УИХ-ын Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо 2016 оны арваннэгдүгээр сарын 15-ны өдөр аж ахуйн нэгж, эрдэмтэн судлаачдыг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж агаарын бохирдлыг бууруулах чиглэл, зөвлөмжийг гаргасан. Мөн НҮБ-ийн Хүүхдийн сан болон Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгээс “Хүүхдийн Эрүүл мэндэд агаарын бохирдлын үзүүлэх нөлөө, шийдвэрлэх арга зам” судалгааны тайланг хүлээн авах ажлыг зохион байгуулж холбогдох төрийн байгууллага аж ахуй нэгжүүдэд чиглэсэн санал зөвлөмжийг гаргасан. Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо 2016 оны анхдугаар хуралдаанаа зохион байгуулж тодорхой шийдвэрүүдийг гарган хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа” гэдгийг дуулгасан юм. Өмнө нь хийгдэж байсан зүйлийн талаар тэрбээр “Агаар бохирдлыг бууруулах чиглэлээр “Цэвэр агаар сан”-гаас 2011-2015 онд 135 тэрбум төгрөг зарцуулсан ч бодитой үр дүн гараагүй байгаа. Мөн буруу төлөвлөлт, алдаатай бодлого, салбар хоорондын уялдаагүй байдлын улмаас гэр хорооллын дахин төлөвлөлт, орон сууцжуулах хөтөлбөрүүд ч бодитой хэрэгжээгүй. Түүнчлэн Н.Алтанхуягийн тэргүүлсэн Засгийн газраас “Нүүрс” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн нь мөн л асуудал дагуулж сайжруулсан болон шахмал түлшний үйлдвэрүүдийн хаалгыг барихад хүргэсэн. Тиймээс цаашид өнгөрсөн алдаагаа давтахгүй, салбар хоорондын бодлогынуялдаагхангажажиллах шаардлагатай байна. Түүнчлэн өнөөгийн хөрөнгө санхүүгийнхээ нөхцөлд түшиглэсэн зөв бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэхийг зорьж байгаа. Ер нь бол хамгийн хүчтэй Засгийн газар ч агаарыг бохирдлыг дангаараа шийдвэрлэж чадахгүй. Иргэдийн ухамсар, оролцоо, хариуцлага чухал гэдгийг БОАЖ-ын сайд Д.Оюунхорол онцолсон юм. Тиймээс энэ хүрээнд БОАЖЯ-наас агаарын бохирдлыг бууруулахад иргэдийн оролцоо, мэдлэг мэдээллийг нь нэмэгдүүлэх зорилгоор “Агаарын бохирдлыг бууруулахад - Иргэн таны оролцоо” аяныг ирэх оны нэгдүгээр сарын 01-нээс эхлүүлж байгаа аж.

ЗАСГИЙН ГАЗАР

## ОЛОН ХҮҮХЭДТЭЙ ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭХ, ЭЦЭГТ ТЭТГЭМЖ ОЛГОНО

Засгийн газрын ээлжит бус хуралдаан болж дараахь асуудлуудыг шийдвэрлэжээ. Тухайлбал, Олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд тэтгэмж олгох тухай хуулийн төслийг хэлэлцээд Засгийн газрын гишүүдийн саналыг тусган УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтжээ. Төсөлд, дөрөв хүртэлх насны ихэр хүүхдэд нэг удаа тэтгэмж олгох, жирэмсний таван сартайгаас нь эхлэн таван сарын турш эхэд тэтгэмж олгох, 0-3 насны хүүхдээ асарч байгаа эхэд сар бүр тэтгэмж олгох ажээ. Түүнчлэн гурав буюу түүнээс олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт улирал бүр тэтгэмж олгохоор тусгасан байна. Эдгээр арга хэмжээнд нийтдээ жилд 72.4 тэрбум төгрөг зарцуулахаар төсөлд тусгажээ. Дашрамд дуулгахад, Монгол Улсад нийт хүүхэдтэй 531.1 мянган өрх байгаагийн 16 орчим хувийг өрх толгойлсон ганц бие эцэг, эхчүүд эзэлдэг байна.

### Орлогын албан татварыг нэг хувь болгоно

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-аас эгүүлэн татах саналаасаа Засгийн газар татгалзлаа. Ингэснээр УИХ уг хуулийн төслийг Засгийн газраас анх өргөн барьсан төслөөр нь дахин хэлэлцэхээр болж байгаа юм. Төсөлд, жилийн борлуулалтын орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй хүнсний үйлдвэрлэл, хувцас болон нэхмэлийн үйлдвэрлэл, барилгын материалын үйлдвэрлэл, газар тариалан, мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд нэг хувиар орлогын албан татвар ногдуулахаар тусгажээ. Уг хуулийг баталснаар жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хувьд татварын дарамт буурах, эдгээр салбарт хөдөлмөр эрхлэлт болон ажлын байр нэмэгдэх зэрэг ач холбогдолтой гэж Засгийн газар үзэж байна. Уг хуулийг 2017 оны нэгдүгээр сарын 01-нээс дагаж мөрдөхөөр Засгийн газраас боловсруулсан төсөлд тусгажээ.

### Вакцины зардлыг малчин өөрөө төлдөг болно

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн төсөл, түүнтэй нийцүүлэн холбогдох зарим хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэн дэмжиж Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусган УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтжээ. Төсөлд, одоо мөрдөж байгаа хүчин төгөлдөр хуульд зохицуулалтгүй байгаа асуудлуудыг шинээр тусгах аж. Мөн бүх төрлийн халдварт өвчнөөс сэргийлэх вакцины үнийг улсын төсвөөс санхүүжүүлж байсныг өөрчилж, зарим халдварт өвчнөөс сэргийлэх вакцины үнэ, үйлчилгээний хөлсийг орон нутгийн төсвөөс болон мал, амьтны эзнээс гаргах зэрэг харилцааг шинэчлэн зохицуулжээ.

## Ц.Мөнх-Оргил: Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд Далай лам Монгол Улсад айлчлахгүй



Ж.МЯГМАР

Далай ламын айлчлалын талаархи засгийн газрын байр суурь, давхар иргэншлийн асуудлаар Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил сэтгүүлчдэд мэдээлэл өглөө. Мэдээллийн эхэнд тэрбээр “Би Далай ламын айлчлалын асуудлаар “Өдрийн сонин”-д ярилцлага өгсөн. Ингэхдээ хувь хүний бус Засгийн газрын байр суурийа илэрхийлсэн. Өөр дотоод гадаадын хэвлэлд ярилцлага, мэдэгдэл өгөөгүй. Монгол Улс “Нэг Хятад”-ын бодлогыг тууштай баримталж ирсэн. Цаашид ч баримтална. Түвд бол БНХАУ-ын бүрэлдэхүүн хэсэг. Энэ бол БНХАУ-ын язгуур эрх ашгийн асуудал. Далай ламын Монгол Улсад шашны байгууллагын шугамаар хийсэн айлчлал улс төрийн ямар нэг үйл ажиллагаа явуулаагүй. Гэсэн хэдий ч энэ айлчлалаас болж хоёр улсын хооронд үл ойлголцох харилцаа бий болсон. Үүнд манай улс харамсаж байгаагаа илэрхийлсэн. Энэ айлчлалыг зохион байгуулахад УИХ, Засгийн газар оролцоогүй. Харамсалтай нь энэ айлчлалын асуудал хоёр орны харилцааны, үүнээс улбаалаад эдийн засгийн санхүүгийн үр дагавартай асуудал болсон. Энэ бүхнийг харгалзаад энэ Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд Далай лам Монгол Улсад айлчлахгүй гэсэн байр суурьтай байгаагаа илэрхийлсэн. Х Богд шашны асуудал. Тиймээс Засгийн газар оролцохгүй. Би зөвхөн Засгийн газрын байр суурийг энэ хэмжээнд тайлбарлаж ярина” гэлээ. Харин сүүлийн үед хэвлэл мэдээллийн хэрэгслээр яригдаад байгаа давхар иргэншлийн асуудлаар тэрбээр “Давхар иргэншлийн асуудлаар “Өдрийн сонин”-д сэтгүүлч байр суурийа илэрхийлсэн байсан. Гэтэл энэ нь миний өгсөн ярилцлага мэтээр ойлгогдож цахимаар түглээ. Үүнд “Өдрийн сонин” залруулга гаргасан. Давхар харъяаллын хувьд ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга н.Баясгалангаар ахлуулсан ажлын хэсэг гарч ажиллаж байгаа. Гадаадын 78 оронд ажиллаж, амьдарч байгаа 130 мянга гаруй иргэдийг төлөөлөөд 400 гаруй төрийн бус байгууллага хоёр асуудал тавьсан. Зарим тохиолдолд монголчуудыгаа эргээд харъяалалд нь аваач ээ, мөн гадаадад амьдарч ажиллаж байгаа иргэдийн хүүхдийг сурч боловсроход нь дэмжлэг үзүүлээч гэсэн асуудлыг тавьж байгаа. Үүнийг судалж, дэмжих хэрэгтэй. Үүнийг гуйвуулаад олон мянган гадаад иргэдийг Монголын харъяалалд оруулах гэж байгаа мэт улстөржүүлжээ. Дэлхийн 172 улсаас давхар харъяаллыг 51 нь зөвшөөрдөггүй, 50 нь зөвшөөрдөг. Үлдсэн 71 нь зарим тохиолдолд зөвшөөрдөг. Манай улс зөвшөөрдөггүй 51 улсад хамаардаг. Харин бид өнөөдөр зарим тохиолдолд зөвшөөрдөг улсынх нь тоонд орох уу гэдгийг судалж байна. Ингэхдээ гадаадын иргэнийг Монгол Улсын харъяат болгохгүй. Монгол аав, ээжтэй хүүхэд гадаадад төрөөд, гадаад иргэн болсон тохиолдолд монгол улсынхаа иргэн болгохоор судалж байна. Хятад улс угаасаа давхар харъяалал зөвшөөрдөггүй. Тиймээс Хятадуудыг харъяалалдаа авах нь гэж улстөржүүлэх хэрэггүй” хэмээсэн юм. 2017 онд гадаад харилцааны салбарын батлагдсан төсөв 14 тэрбум төгрөгөөр хэмнэгдсэн гэнэ. Мөн ханшны зөрүүгээс 1.2 сая ам.доллар алдаж байгааг Гадаад харилцааны сайд дуулгалаа. Хэмнэлтийн хүрээнд УИХ-аас үүрэг болгосны дагуу зарим ЭСЯ, Консулын газруудыг татан буулгахаар болсон гэх асуудал яригдаад байгаа. Тэгвэл энэ талаар тэрбээр “Индонезид манай 27, Бразильд манай 25 иргэн амьдар байгаа гэнэ. Худалдаа эргэлт нь 10 сая ам.долларт багтдаг байна. Жилдээ 400-500 мянган ам.долларын зардал гардаг гэнэ. Тиймээс Бразиль, Индонези дэх ЭСЯ, БНХАУ-ын Хайлаар, Японы Осака дахь консулын газраа татаж буулгахаар санал оруулж байгаа юм байна. Ингэснээр жилдээ 1.6-1.8 сая ам.долларын хэмнэлт гаргах болно” гэлээ.

## Хөөт-Бичигт, Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг үнэгүй боловсруулахаар болов

“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын эхний үе шатанд баригдахаар төлөвлөсөн Чойбалсан-Хөөт, Засгийн газрын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрт тусгасан Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын Техник эдийн засгийн үндэслэлийг БНХАУ-ын “Си Ар И Си” компани өөрийн зардлаар боловсруулахаар болж, “Монголын төмөр зам” ТӨХК-тай өнөөдөр санамж бичиг байгуулж, гарын үсэг зурлаа. Энэ сарын 21-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар “Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам барьж байгуулах тухай” УИХ-ын тогтоолын төслийг дэмжиж, УИХ-д өргөн мэдүүлэхээр болсон билээ.

Энэ хүрээнд Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат БНХАУ-ын “Си Ар И Си” компанийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, санал солилцсоны үр дүнд тус компани ТЭЗҮ-ийг олон улсын болон үндэсний стандартад нийцүүлэн боловсруулж, “Монголын төмөр зам” ТӨХК-д үнэ төлбөргүй хүлээлгэн өгөхөөр болжээ.

Чойбалсан-Хөөт чиглэлийн төмөр замын нийт урт нь 192 км, Зүүн хойд Азийн эдийн засгийн бага хурлаас 2000 онд тээврийн коридоруудыг тодорхойлсон. Эдгээр коридорын нэг нь Монгол Улсын төмөр замын хэтийн төлөвтэй уялдуулан “Боорж-Эрээнцав-Чойбалсан-Хөөт-Бичигт-Чанчунь чиглэлийг улс, бүс нутгийн хамтын ажиллагааны хөгжилд чухал ач холбогдолтой” гэж тэмдэглэл гарсан байдаг.

Улсын Их Хурлын 2014 оны 64 дүгээр тогтоолоор Чойбалсан-Хөөт чиглэлийн 192 км төмөр замыг 1520мм-ийн царигтайгаар барьж байгуулахаар тусгасан. Энэ нь цаашлаад БНХАУ-ын төмөр замаар дамжин өнгөрч, далайн боомтоор гуравдагч оронд бүтээгдэхүүн тээвэрлэх боломж үүсэх юм.

Чойбалсан-Хөөт чиглэлийн төмөр замын хээрийн судалгааны ажил, трассын дагуух төмөр замын зурвас газарт археологи, палентеологийн судалгааны ажил 2013 онд 100% хийгдэж дууссан. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийж, техникийн зураг төслийг боловсруулж дууссан байна. Төслийн хүрээнд Техник, эдийн засгийн үндэслэлийг 2017 оны эхний хагас жилд багтаан гүйцэтгэж, 281 орчим км төмөр замын барилгын ажлыг 2018-2020 онуудад барьж дуусгахаар төлөвлөн ажиллаж байгаа юм.

Эдгээр төмөр замууд баригдсанаар уул уурхайн бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах, эдийн засгийн хүндрэлтэй байдлыг даван туулахад чухал ач холбогдолтой аж. 2018-2025 онд жилд тээвэрлэх ачааны хэмжээг 10-21 сая тонн, 2026-2046 онд 21 сая тонн гэж үзвэл дээрх чиглэлийн төмөр замаар тээвэрлэх ачааны доод хэмжээ дунджаар 15 сая тоннд хүрэх төлөвтэй байна.

МЭДЭЭЛЭЛ

# ИРГЭНЭЭ ДЭЭДЭЛСЭН УЛААНБААТАР

–Улаанбаатар хотын 2016 оны онцлох 10 ажил–
Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч болон нийслэлийн удирдлагын шинэ баг ажлаа хүлээн аваад 6 сар өнгөрчээ. Энэ хугацаанд хийж хэрэгжүүлсэн онцлох 10 ажлыг танилцуулж байна.



## 1. Нийслэлийн Засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэллээ

НИТХ-ын Анхдугаар хуралдаанаас нийслэлийн Засаг даргад С.Батболдын нэрийг дэвшүүлснийг Монгол Улсын Ерөнхий сайд 2016 оны долоодугаар сарын 6-ны өдөр батламжилж, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаар томилсон билээ. НИТХ-ын ээлжит гуравдугаар хуралдаанаар нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболдын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцэн баталсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр нийслэл хот нь иргэнээ дээдэлсэн, өндөр технологид суурилсан үйлдвэрлэл, бие даасан эдийн засагтай, бизнест ээлтэй, ногоон хөгжлийн үзэл баримтлал бүхий олон улсад өрсөлдөх чадвартай, үндэсний хэв маяг, өвөрмөц дүр төрхтэй, Зүүн хойд Азийн санхүү, бизнес, аялал жуулчлалын төв хот болно. НИТХ-ын тавдугаар хуралдаанаар "Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийг хэлэлцэж, батлав. Мөн Нийслэлийн Засаг даргаас өргөн барьсан "Нийслэлийн 2017 оны төсөв"-ийг НИТХ хуулийн хугацаанд нь хэлэлцэн баталсан. Хотын удирдлагууд ирэх оны төсвөөр "Иргэдийн оролцоотой төсөв" нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулсан юм.



## 2. Дахин төлөвлөлт, дэд төвүүд

Улаанбаатар хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд нийслэлийг найман дэд төвтэй байхаар төлөвлөсөн. Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлэх "Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих" хөтөлбөр нь эдийн засгийн боломж, орон сууц, хотын дэд бүтцийн үйлчилгээ хангамж бүхий эрүүл аюулгүй, тав тухтай амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлсэн, бие даан хөгжсөн дэд төвийн сүлжээг гэр хороололд бий болгох зорилготой юм. Эхний ээлжинд Баянхошуу болон Долоон буудал орчмын Сэлбэ дэд төвийг байгуулахаар ажиллаж байгаа билээ. Эдгээр дэд төвүүдэд 200 мянга орчим хүн оршин суух боломжтой, нийгмийн үйлчилгээ, инженерийн байгууламжийг цогцоор нь шийдэх хөтөлбөр бөгөөд эхний ээлж 2014-2016 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Гэр хорооллын дахин төлөвлөлтийг зөв бодлого, зөв шийдлээр хэрэгжүүлж эхэлллээ. Энэ ажлын хүрээнд гэр хорооллын дахин төлөвлөлтөөс хохирсон 232 өрхийг ид хүйтнээс өмнө амжиж түрээсийн шинэ орон сууцанд оруулж, түлхүүр гардуулсан. Мөн ашиглалтын шаардлага хангахгүй барилгуудыг дахин барилгажуулах төслийн анхны орон сууцыг ашиглалтад оруулж, байрны эздэд түлхүүрийг нь гардуулан өглөө.



## 3. Иргэдээ сонсч, тулгамдсан асуудлыг шийддэг боллоо

Хотын дарга 14 хоногт нэг удаа иргэдтэй уулздаг боллоо. Тэрбээр уулзалтаа албан өрөөндөө бус иргэд рүүгээ ойртож, нийслэлийн дүүрэг, хороо бүрт хүрсэн уулзалт хийхийг зорьсон. Тиймээс нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн "Мишээл", "Драгон", "Дүнжингарав" зэрэг салбарт ажиллаж, иргэдтэй уулзаж байгаа билээ. Хотын дарга иргэдтэйгээ нүүр тулан уулзаж, асуудлыг шийдэж, шийдэх гарц олохын төлөө ажиллаж байгаад иргэд талархаж байгаа юм. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй, амьдралын нөхцөл нь туйлын хүнд З.Мандах, Л.Оюунтуул, Б.Мөнхбаясгалан нарт Ахмадын хотхонд байрлах түрээсийн орон сууцанд амьдрах эрхийн бичиг гардуулсан бол иргэдээс ирсэн газрын маргаантай асуудлуудыг шийдвэрлэж, гудамж талбайн цасыг хялбар аргаар арилгах төхөөрөмж бүтээсэн Ц.Оргилболдын санаачилгыг дэмжиж уг төхөөрөмжийг худалдан авсан гээд олон шийдэл, шийдвэрийг дурьдаж болно.



## 4. Нийслэлийн эрх зүйн байдал

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболдын өргөн барьсан Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн. Засгийн газрын хуралдаанаас хуулийн төслийг яаралтай боловсруулж, ойрын хугацаанд Засгийн газрын хуралдаанд оруулахыг хотын даргад үүрэг болгосон юм. Үүний дагуу Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж иргэдэд танилцуулж, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгууллаа. Мөн иргэдээс санал авах ажиллагааг Ulaanbaatar.mn сайтаар дамжуулан хийж байна. Улаанбаатар хот эдийн засаг, нийгмийн харилцааны хувьд өргөжин хөгжиж, эерэг, сөрөг олон асуудал шинээр үүсэхийн хэрээр одоогийн хууль зохицуулалтын чадвараа алдаж, эрх зүйн хийдэл үүсэх тохиолдол давтагдах болжээ. Монгол Улсын нийт хүн амын бараг тал хувь нь оршин суух нийслэл хотын хөгжлийн үзэл баримтлалыг шинээр тодорхойлох, түүнд нийцүүлэн, эрх зүйн шинэ орчин бүрдүүлэх шаардлага тулгарч байгаа юм. Энэхүү хэрэгцээ, шаардлагыг харгалзан, нийслэлийн Засаг дарга С.Батболд өнгөрсөн хугацаанд уг хуулийн төслийг санаачлан боловсруулсан юм.



## 5. Аюулгүй Улаанбаатар

Нийслэлийг телекамерийн хяналтад бүрэн авлаа. Ингэснээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэргийг илрүүлэх, иргэдийг амар тайван амьдрах "Аюулгүй хот" төслийг хэрэгжүүлэхэд чухал ахиц авчрах юм. Мөн хулгай, дээрмийн гэмт хэргийг бууруулахад засаг захиргаа, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд оршин суугчдын хамтын ажиллагаа оролцоог сайжруулах зайлшгүй шаардлагатай байдаг. Энэ хүрээнд 2016 онд 2500 иргэнийг хэв журмын урамшуулалт эргүүлд ажиллуулж байгаа нь зохих үр дүнгээ өгсөн ажил байлаа. Нийслэлийн Засаг даргын ирэх дөрвөн жилийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт "Түгжрэлгүй гудамж, бухимдалгүй хот" гэсэн дэд хэсэг тусгагдсан. Энэ хүрээнд 16 уулзвараар гэрлэн дохио хамаарахгүйгээр баруун гар тийш эргэдэг болов. Ингэснээр уулзваруудын ачаалал буурч, нэвтрэх чадвар нэмэгдэн хотын авто замын түгжрэлийг зохих хэмжээгээр бууруулсан арга хэмжээ боллоо.









## 6. Эрүүл иргэн

Хавдар судлалын үндэсний төв \ХСҮТ\-д хавдраар шаналсан иргэд Монгол Улсын өнцөг булан бүрээс ирж үйлчлүүлдэг. Элэг шилжүүлэн суулгуулах шаардлагатай иргэдийн 50 хувь Улаанбаатар хотын иргэд байгаа юм. ХСҮТ, "Элэг бүтэн Монгол" сантай хамтран элэг шилжүүлэн суулгах хагалгаа хийхэд шаардлагатай тоног төхөөрөмж авах 1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нийслэлээс шийдвэрлэж, хамтран ажиллах "Санамж бичиг"-т нийслэлийн Засаг дарга гарын үсэг зурсан. Санамж бичгийн хүрээнд оны өмнөхөн 18 нэр төрлийн нэн шаардлагатай тоног төхөөрөмжийг Хавдар судлалын үндэсний төвд хүлээлгэн өглөө. Амьсгалын замын цочмог халдвар ихэсч, бага насны хүүхдүүдийн дунд өвчлөл нэмэгдэхийн хэрээр дүүргийн эмнэлгүүдийн ачаалал ихэсч, орны хүрэлцээ тун тааруу болсон. Уг асуудалтай хотын дарга газар дээр нь явж танилцаад Сонгинохайрхан дүүргийн хүүхдийн эмнэлэгт нэн шаардлагатай амьсгалын аппарат зэрэг багаж хэрэгслийг өгсөн. Мөн тус дүүргийн амбулаторийн нэгдүгээр давхрыг чөлөөлж, 70 хүртэл ортой тасаг шинээр нээж ажиллууллаа. Иргэдэд түргэн тусламжийн үйлчилгээг хугацаа алдалгүй хүргэхэд туулах чадвар сайтай автомашин зайлшгүй шаардлагатай байдаг. НЗДТГ-аас Нийслэлийн түргэн тусламжийн төвд "Kia Bongo" маркийн иж бүрэн тоноглогдсон 10 автомашин хүлээлгэн өгсөн нь түргэн тусламжийн үйлчилгээнд дэвшил авчирсан явдал байлаа. Амьсгалын замын өвчлөлөөс сэргийлэх гол арга бол амны хаалт гэж мэргэжилтнүүд хэлдэг. Нийслэлээс бүх нийтийн "Маск зүүж хэвшицгээе" аяныг өрнүүлж, иргэдэд 60 мянган амны хаалт үнэгүй тараав. Аяныг "Оюутолгой" ХХК дэмжиж, нийгмийн хариуцлагынхаа хүрээнд 20 мянган ширхэг амны хаалт өгсөн байна. Нийслэлийн Эрүүл мэндийн газраас амны хаалтыг утаа ихтэй, гэр хорооллын Өрхийн эрүүл мэндийн 70 гаруй төвөөр дамжуулан иргэдэд тараав.






## 7. Улаанбаатарыг хөгжүүлэх томоохон төслүүд хөдөлж эхэллээ

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд "Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг зохион байгуулах тухай" А/614 дүгээр захирамж гаргалаа. Захирамжаар нийслэлийн Засаг даргын тамгын газар, харьяа агентлагуудын бүтэц өөрчлөгдөн батлагдсантай холбогдуулан Тусгай замын автобус буюу BRT төслийг яаралтай, үр өгөөжтөй хэрэгжүүлэх ажээ. Ингэхийн тулд Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлэх "Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хариуцагч, гүйцэтгэгч байгууллагын төслийн нэгж байгуулах, удирдан зохион байгуулалтаар хангах зэрэг үйл ажиллагаатай холбоотой чиг үүргийг гүйцэтгэхийг "Улаанбаатар хотын хөгжлийн корпораци" нийслэлийн өмчит хувьцаат компанид хариуцуулав. Мөн Улиастайн уулзвараас Налайх хүртэлх 20.9 км дөрвөн эгнээтэй зам, төмөр замын гарам нэвтрэх давхар гүүр, Баянзүрх, Сонсголон, Яармагийн одоогийн гүүрийг хос болгох зэрэг ажлыг БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр барихаар төлөвлөөд байна.



## 8. Бүтээн байгуулалт

Нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвтэй боллоо. Уг төв нь болзошгүй гамшгийн аюулаас өөрийгөө болон бусдыг хэрхэн хамгаалах, аврах мэдлэг, дадлыг иргэд, олон нийтэд олгож, сургалт, дадлагад хамруулах юм. Тухайлбал, газар хөдлөлтийн гамшгийн зарлан мэдээллийн дохиогоор ажиллаж, обьектыг орхин хэрхэн аюулгүй орчинд гарах, өөртөө болон бусдад эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг ашиглаж сурах зэрэг иргэдийн мэдвэл зохих анхан шатны мэдлэг, дадлыг олгох аж. Уг төв нь гамшгаас хамгаалах сургалт, дадлага зохион байгуулахаас гадна дуудлагаар ажиллах Аврах ангитай иж бүрэн цогцолбор байгууламж юм байна. Хан-Уул дүүрэгт байрлах "ДЦС 3"-ын баруун хойд замыг Яармагийн гүүртэй холбов. Мөн нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Их Монгол Улсын гудамжны 2.1 км авто замын өргөтгөл шинэчлэлтийн ажил хийгдлээ. Шинэчлэлтийн ажлын хүрээнд 7 м өргөнтэй зорчих хэсгийг 14 м өргөнтэй 4 эгнээ болгон өргөтгөж, явган хүний зам, дугуйн зам, гэрэлтүүлэг, борооны ус зайлуулах систем зэрэг ажлууд хийгдэв. Шастины нэрэмжит Улсын III төв эмнэлгийн урд талд орчин үеийн стандарт бүхий 140 машины авто зогсоолыг иж бүрнээр нь шийдэж, ашиглалтад оруулаа. Богино хугацаанд хийсэн энэ зогсоол эмнэлгийн байгууллага, иргэдийн талархлыг хүлээсэн юм. Мөн нийслэлийн Замын сангийн хөрөнгө оруулалтаар 300 сая төгрөгийн өртөг бүхий нийтийн тээврийн хэрэгслийн зориулалтын зогсоолыг 14 байршилд барьж байгууллаа.





## 9. Байгал орчин, хот тохижилт

Нийслэл хот үүсэн байгуулагдсаны 377 жилийн ойг угтан НЗДТГ, нийслэлийн Аялал жуулчлалын газар хамтран Богдхан уулын "Зайсан-Баруун ширээт" чиглэлийн 3.6 км явган аяллын замд иж бүрэн тохижилт хийлээ. Энэ нь иргэдийг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломжийг бүрдүүлсэн олон улсын стандартын дагуу хийгдсэн явган аяллын анхны зам юм. Улаанбаатар хотын иргэдийг эрүүл цэвэр агаарт амарч, зугаалах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Хүй долоон худаг дахь "Монгол наадам цогцолбор"-т нэг дор 100 хүн хүлээн авах чадвартай "Ub Resort" цанын баазыг нээлээ. Тус бааз цана, чарга, тэшүүр, дулаан гэр, халуун хоол цайгаар үйлчлэх гээд иргэдэд аюулгүй, таатай орчинд амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүллээ. Толгойтоос Амгалан өртөө хүртэл 17 км төмөр замын хамгаалалтын зурвас, төмөр замын хоёр талаар 4 м өндөртэй 8000 ширхэг сибирийн нарс мод тарив. Түүнчлэн хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч Хонхтой цэцэрлэгт хүрээлэн, Клиникийн II эмнэлгийн урд нарс мод тарилаа.

## 10. Газар зохион байгуулалтыг шинэ шатанд гаргалаа



Иргэдийн аз жаргалтай амьдралын үндэс нь эрүүл, аюулгүй, амгалан тайван орчинд амьдрах явдал. Энэ эрхийг баталгаажуулах үүднээс Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд захирамж гаргасан. Газар зохион байгуулалтыг шинэ шатанд гаргах ажлын эхлэл болсон хотын даргын захирамж нийтийн зориулалттай орон сууцны хороолол дундах болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн ойр орчмын нийтийн эдэлбэр газарт орон сууц, конторын барилга барих зориулалтаар газар шинээр олгохгүй байх тухай байлаа. Нийслэлийн оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, зүлэг мод, бут сөөг, гэрэлтүүлэг, хүүхдийн тоглоомын талбайг нэмэгдүүлэхэд уг захирамжийн ач холбогдол оршиж байгаа юм.

## ФОТО СУРВАЛЖЛАГА



# АГААРЫН БОХИРДЛЫН ЭСРЭГ БҮХ НИЙТЭЭРЭЭ ХАМТАРЧ АЖИЛЛАХЫГ УРИАЛЛАА




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Ээж аавууд утааны эсрэг Сүхбаатарын талбайд анх удаа тайван жагсаал хийлээ. Жагсаал 12:00 цагт эхэлж, 14:00 цагт дууссан юм. Тэд утааны эсрэг нэн яаралтай дорвитой арга хэмжээ авахыг төр засгийн сонорт хүргэхийн тулд ийн жагссан юм. Энэхүү жагсаалын хүрээнд эцэг, эхчүүд төр, засагт хандан агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг яаралтай гаргахыг хүссэн өргөдөл гаргаж байгаа аж. Түүнчлэн агаарын бохирдол ихтэй байгаа энэ үед шуурхай арга хэмжээ авах, агаарын бохирдол ихтэй үед түгшүүрийн дохио өгөх, агаарын бохирдол ихтэй бүсэд байгаа эхчүүд хүүхдийг тэндээс гаргах, агаарын бохирдлын талаар ажлын тайлангаа нийтэд тайлагнахыг шаардсан байна. Нийтдээ 900 ба түүнээс дээш тооны өргөдөл цугласнаар УИХ-ын Өргөдлийн байнгын хороонд хандах эрхтэй болох аж.
























# ДЭЛХИЙ

## ИРЭХ 2017 ОНД БОЛОХ 10 ТОМООХОН ҮЙЛ ЯВДАЛ



**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

**2017-01-01 АНУ-ын Нью-Йоркт**
АНУ-ын Нью-Йорк хотод байрлах НҮБ-ын төв байранд энэ өдөр тангараг өргөх ёслолын ажиллагаа болох учиртай. Тодруулбал, Португалийн Ерөнхий сайд асан Антонио Гутеррес НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын албан тушаалд албан ёсоор томилогдох бол эсрэгээр 10 жил тус байгууллагыг тэргүүлсэн Бан Ги Мүн суудлаа шилжүүлэх билээ.

**2017-01-20 АНУ**
Америкчууд төдийгүй, дэлхий нийтийн гайхшруулан АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд төлөөлөгчдийн саналаар тэргүүлсэн үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп энэ өдөр тангаргаа өргөнө. Ингэснээр тэрбээр тус улсын 45 дахь Ерөнхийлөгч болж түүхэнд нэрээ мөнхлөх юм. Харин америкчууд түүхэн дэх хамгийн баян, улс төрийн туршлагагүй, цэргийн алба хаагаагүй анхны Ерөнхийлөгчөө угтан авна. Трамп тангаргаа өргөснөөр Барак Обамагийн улс төрийн бодлого орвонгоороо өөрчлөгдөнө гэдгийг ажиглагчид хэлж буй.

**2017-03-31 Их Британи**
Их Британийн Ерөнхий сайд Тереса Мэй ЕХ-ны үндсэн нөхцөл болох Лисбоны гэрээний 50 дугаар зүйлийг хэрэгжүүлж эхлэх юм. Энэ нь Их Британи улс Европын холбооноос гарах анхны алхам болно.

**2017-04-23 Франц**
Францын Ерөнхийлөгчийн сонгуулийн эхний сунгаа энэ өдөр орон даяар явагдана. Харин тус санал хураалтад хамгийн өндөр санал авсан нэр дэвшигчдийн шийдвэрлэх санал хураалт тавдугаар сарын 7-нд болох юм. Сонгуульд эрх баригч намаас Ерөнхий сайд асан Мануэль Валлс өрсөлдөх бол өнөөгийн төрийн тэргүүн Франсуа Олланд нэр дэвшихгүй.

**2017-05-19 Иран**
Энэ өдөр Ираны Ерөнхийлөгчийн сонгууль болно. Сонгууль өнөөгийн төрийн тэргүүн Хассан Рухани улиран сонгогдож, хоёр дахь бүрэн эрхийн хугацаагаа үргэлжлүүлэх төлөв ажиглагдаж буйг ажиглагчид онцолж байгаа. Ираны түүхэн дэх 12 дахь Ерөнхийлөгчийн сонгуульд 18-аас дээш насны иргэд оролцон өөрсдийн төлөөлөлдөө саналаа өгөх юм.

**2017-08-04 Их Британи Лондон**
Их Британийн Лондон хотод энэ өдөр 16 дахь удаагийн хөнгөн атлетикийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн болно. Тус тэмцээн наймдугаар сарын 13-ны өдрийг хүртэл үргэлжлэх юм.

**2017-08-08 Кэни**
Кэничүүд энэ өдөр шинэ Ерөнхийлөгчөө сонгоно. Насанд хүрсэн 22 сая хүн уг сонгуульд оролцож саналаа өгөх юм.

**2017-09-12 Перу**
Олон улсын Олимпийн хорооны их хурал энэ өдөр болно. Энэ хурлаар 2024 оны өвлийн олимпийг зохион байгуулах хотыг тодруулах юм.

**2017 он 09-10 сар Герман**
Германы парламентын сонгууль болно. Тус сонгуульд Германы канцлер Ангела Меркель Христийн ардчилсан холбоо намаа удирдан оролцох юм. Хэрэв түүний тэргүүлж буй нам ялалт байгуулвал А.Меркель дөрөв дэх удаагаа улиран сонгогдсон канцлер болох билээ.

**2017-11-06 Германы Бонн**
НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийн 23 дугаар уулзалт энэ өдөр болох бөгөөд уулзалтыг Фижи зохион байгуулна. Уулзалт 17-ны өдрийг хүртэл үргэлжилнэ.

## Филиппинийг хар салхи дайрлаа

Филиппиний нутгийн зүүн хэсгийг 225 км/ц-ийн хурдтай, хүчтэй хар салхи дайран өнгөрчээ.Орон нутгийн цагаар ням гарагийн 18:30 цагийн үед тус улсын Катандуанес арал орчмын эргээр "Нок-Тен" хар салхи дайран өнгөрсөн байна. Хүний амь эрсэдсэн болон эд материалын хохирол учирсан гэх мэдээлэл ирээгүй байна. Гэхдээ хар салхи дайран өнгөрсний улмаас үер усны аюул нүүрлэж, хөрсний нуралт үүсч болзошгүй байгаа тул тус улсын Биколь мужаас 100 мянга орчим оршин суугчийг нүүлгэн шилжүүлжээ. Мөн хоёр метр өндөртэй давалгаа үүсч болзошгүй гэж анхааруулсан тул хэдэн арван боомтыг хаасан аж. Одоо энэ хар салхи тус улсын гол арал болох Лусон руу чиглэн урагшилж байгаа бөгөөд нийслэл Манила хотод дөхөж ирэх үед хүч нь сулрах төлөвтэй байна. Манила хот дахь зар сурталчилгааны самбаруудыг буулгахыг холбогдох албаны хүмүүс үүрэг болгожээ. Хүчтэй салхи хөдөлснөөр самбарууд унаж олон хүнийг гэмтээж бэртээж болзошгүй гэж албаны хүмүүс үзэж байна. Хар салхинаас сэргийлэн аюулгүй газарт очихыг холбогдох албаны хүмүүс уриалсаар байна. Гэсэн хэдий ч хүмүүс Зул сарын баяраар гэртээ гэр бүлийнхэнтэйгээ хамт байхын тулд энэ анхааруулгыг үл ойшоож байж магадгүй юм. Зул сарын баяр бол католик шашинт тус улсын ард иргэдийн хувьд хамгийн том баяр билээ. 2013 онд тус улсыг "Хайян" хар салхи дайран өнгөрснөөр 7350 гаруй хүн амиа алдаж байжээ.

## Индонезид халдлага үйлдэхээр төлөвлөсөн байсныг илрүүллээ

Индонезийн Баруун Ява мужид цагдаагийн албан хаагчдыг онилон халдлага үйлдэхээр төлөвлөж байсан хоёр сэжигтнийг буудан устгажээ. Тус улсын ЦЕГ-ын хэвлэлийн төлөөлөгч мэдэгдэхдээ "Хоёр сэжигтнийг Баруун Ява мужийн Пурвакара хот дахь нэгэн байшинд байх үед нь терроризмтой тэмцэх тасгийн цагдаагийн ажилтнууд устгасан" гэжээ. Энэ хоёр этгээд хэт даврагч "Лалын улс" бүлэглэлийг дэмждэг Индонез дэх нэгэн бүлэглэлийн гишүүд байсан аж. Тэдний байсан газраас халдлага үйлдэх төлөвлөгөө болон хурц иртэй хэд хэдэн хутгыг цагдаа нар илрүүлсэн байна. "Лалын улс"-ыг дэмжигчдийн халдлага үйлдэх гэсэн хэд хэдэн төлөвлөгөөг Индонезийн цагдаа нар сүүлийн өдрүүдэд илрүүлж, таслан зогсоосон юм. Тус улсын Засгийн газар Зул сар болон шинэ жилийн баярын оргил өдрүүдэд террорист халдлага гарахаас сэргийлж, улс орон даяар 100 мянган цэрэг, цагдааг эргүүл хамгаалалтад дайчилжээ.

## Сүйрсэн онгоцыг туршлагатай нисгэгч жолоодож явжээ

ОХУ-ын цэргийн зориулалттай Tu-154 онгоц Адлер хотоос Сирийн Латакиа дахь агаарын цэргийн хүчний баазыг чиглэн хөөрснөөсөө хойш 20 минутын дараа радарын дэлгэцээс алга болсон билээ. Улмаар яаралтай эрлийн баг гарч эрэн хайсны дүнд онгоцны сэг болон хохирогчдын цогцсыг Сочи хотоос холгүй хар тэнгисийн эргээс 1.5 км зайд 50-70 метрын гүнд сүйрсэн байгааг олж илрүүлсэн байдаг. Онгоцонд зорчиж явсан хүмүүсийн найм нь нисэх багийн гишүүн, 64 нь "Александрова ансамбль" цэргийн чуулгын уран бүтээлч байсан бол ес нь сэтгүүлч байжээ. Ослоор амьд үлдсэн нэг ч хүн байхгүй аж. Одоогоор онгоцны ослын шалтгаан тодорхойгүй байна. Гэхдээ албаныхан нисгэгчийн буруутай үйлдэл, эсвэл техникийн доголдлоос болж сүйрсэн эсэхийг тогтоохоор ажиллаж буй гэнэ. Сүйрсэн онгоцыг 1983 онд үйлдвэрлэсэн бөгөөд 6689 цагийн нислэг үйлдсэн байжээ. Хамгийн сүүлд 2014 оны арванхоёрдугаар сарын 29, 2016 оны есдүгээр сард засварласан байна. Мөн онгоцыг туршлагатай нисгэгч жолоодож явсан аж. Онгоцыг Роман Волков гэгч нисгэгч жолоодож явсан байх бөгөөд тэрбээр 3000 цаг ниссэн туршлагатай байжээ. Ямартай ч, цаг агаарын таагүй уур амьсгалаас үүдэн онгоц сүйрсэн байх магадлалтай гэдгийг зарим эх сурвалж онцолж байна.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

# АШУҮИС-ИЙН ОЮУТНУУД СЭТГЭЛЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ АВНА

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**







Оюутны сэтгэл зүйн төвийг нээж, тус сургуулийн захирал Г.Батбаатар "Залуучуудад зориулсан сэтгэлзүйн зөвлөгөө өгөх төвийг нээж байна. Энэ бол олон улсад тавигддаг шаардлагуудын нэг нь. Манай сургууль олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц бүсийн шилдэг их сургууль болно гэсэн эрхэм зорилгынхоо хүрээнд сэтгэлзүйн төвийг заавал байгуулах ёстой. Тийм учраас сургуулийнхаа Оюутны холбооны хүсэлт болон Сэтгэцийн төвийн шууд оролцоотойгоор энэхүү төвийг байгууллаа. Ахлах бүлгийн төгсөх ангийн сурагчид сургуулиа төгсөөд огт өөр орчинд ирдэг. Их сургууль хэмээх биеэ даадаг, өөрийгөө дайчилдаг, маш олон оюутнуудтай орчинд орж ирдэг. Манай сургуулийн оюутнуудын хийсэн судалгаагаар оюутнуудад сэтгэлзүйн асуудал их тулгардаг. Нийт оюутнуудын 20 орчим хувь нь сэтгэл санааны ямар нэгэн асуудалтай тулгарч байдаг.

Тэгэхээр тэд энэ асуудлаа яаж шийдэх юм. Үүнд хэн туслах вэ гэж бодохоор энэ зөвлөгөө өгөх төв зайлшгүй шаардлагатай. Бид зөвхөн эрдэм мэдлэгтэй оюутнуудыг бэлтгэн гаргах ёсгүй. Манай сургууль оюутнуудаа эрдэм мэдлэгийг заахаас гадна хүн болгох, нийгэмшүүлэх, ирээдүйн аав, ээж болоход нь бэлдэх гэсэн их том үүргээ умартаж явсан юм билээ. Тиймээс бид хожуу ч гэсэн умардсан зүйлээ санаж оюутнуудаа зөв төлөвшүүлэх, боловсруулах, хүмүүжүүлэх, өөрийгөө нийгэмд зөв авч явж, таниулахад нь туслахын тулд энэ төвийг байгуулж байна" гэв. Энэхүү төв нээгдсэнээр оюутнууд өөрт тулгамдсан сэтгэлзүйн асуудлаа шийдвэрлүүлж, үнэ төлбөргүй зөвлөгөө авах боломж бүрдэж байгаа аж. Энэ үеэр тус сургуулийн сэтгэцийн эрүүл мэндийн тэнхимийн багш, анагаах ухааны доктор Д.Оюунсүрэн "Миний хувьд энэ салбарт 20 гаруй жил ажиллан судалгаа хийж байна.

Энэ хугацаанд оюутнуудад сэтгэлзүйн зөвлөгөө нэн шаардлагатай болох нь харагдсан. Ялангуяа шинэ оюутны хувьд их сургуулийн амьдралд дасахын хажуугаар нийгэмд бие хүн болж төлөвших явц зэрэгцдэг. Орон нутгийн оюутан л гэхэд наад зах нь олон чиглэлтэй автобусаар төөрөхгүй явах, хүмүүстэй харилцахаас эхлээд сэтгэлийн хямралд ордог. Сэтгэлзүйн наад захын асуудлуудаа хүндээр тусгаж, хуримтлуулсаар сүүлдээ сэтгэлзүйн ноцтой асуудалд ордог. Энэ мэтчилэн асуудал тулгамдсан оюутан энэхүү төвөөр үйлчлүүлж зөвлөгөө авах боломжтой. Одоогоор орон тооны сэтгэлзүйч ажиллахгүй. Манай тэнхимийн залуу багш н.Энхтүвшин хариуцаж ажиллана" гэв. Энэхүү төв нь Монголд анх удаа оюутанд зориулсан сэтгэлзүйн төв гэдгээрээ онцлогтой ажээ. Мөн сэтгэлзүйн төвөөр дамжуулан оюутнууддаа үнэ төлбөргүй зөвлөгөө өгч, үйлчлэх бөгөөд тус сургуулийн анагаахын мэргэжлийн багш, сэтгэл засалч нар ажиллах юм байна. Эхний ээлжинд Анагаахын сургуулийн оюутнууд үйлчлүүлэх аж. Харин дараагийн ээлжинд бусад их, дээд сургуулийн оюутныг ч хамруулахаар төлөвлөжээ. Нээлтийн үеэр энэхүү төвийг бусад их дээд сургуулиудад түгээн дэлгэрүүлэх, байгуулах зорилготой гэдгийг тус сургуулийн захирал онцолсон юм.

NO STRESS

ШИНЭ НОМ

# “Дэлхийд түгсэн Монголын нууц товчоо”, “Монголын түүхийн цахим дэлгэрэнгүй толь”-ийн нээлт боллоо



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Б.ДАВАА

“Монголын нууц товчоо”-ны анхны эхийг голлон эх сурвалжаа болгосон, 250 орчим бүтээлийг багтаасан “Дэлхийд түгсэн Монголын нууц товчоо”, Монголын түүхийн тулгуур үйл явдал, түүхэн хүмүүс, түүхэн газар нутаг, засаг захиргааны хамааралтай нэр томъёог шинжлэх ухааны судалгаанд үндэслэн бүтээсэн “Монголын түүхийн цахим дэлгэрэнгүй” толь бүтээлүүдийн нээлт Үндэсний төв номын санд өчигдөр боллоо. Нээлтийн ёслолд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Ц.Баярсайхан, Ерөнхийлөгчийн Хүний хөгжил, нийгмийн бодлогын зөвлөх Р.Болд, ШУА-ийн ерөнхийлөгч Д.Рэгдэл, Монгол Улсын тэргүүлэх зэргийн эрдэмтэд судлаачдын төлөөлөл оролцсон юм. Нээлтийн үеэр Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Бидний өвөг дээдэс Монголын ард түмний бүтээсэн гайхамшигт өв соёл бол эх түүх юм. Өдөр бүр агаараар амьсгалдаг шигээ өв соёлдоо ямар нэг байдлаар бага ч атугай хувь нэмэр оруулбал монгол үндэстний сайн сайхан бие даасан байдал улам баталгаажна гэж би хувьдаа итгэдэг. Эдийн засгийн байдал хүнд байна гэж ярьдаг л юм. Гэхдээ хийе бүтээе гэсэн сэтгэл нь байвал юу ч байсан бүхнийг хийж чаддаг юм байна гэдгийг харлаа. Ерөнхийлөгчийн төсөв 2013 оноос хойш бараг дөрөв дахин буурсан. Жил бүр 30 хувиар бууруулаад явж байгаа. Хамгийн их хасагдсан




нь Ерөнхийлөгчийн төсөв. Гэхдээ л тэр төсвөөсөө мөнгө гаргаж, энэхүү санаачилгыг дэмжсэн” гэсэн юм.

Мөн “Дэлхийд түгсэн Монголын нууц товчоон” бүтээлийн төслийн удирдагчаар ажилласан МУИС-ийн Монгол судлалын хүрээлэнгийн захирал Д.Заяабаатар, “Монголын түүхийн цахим тайлбар толь”-ийн ажлыг удирдсан ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн захирал С.Чулуун нар үг хэлж, тус тусын багийн бүтээлийн онцлог, ач холбогдлын талаар тайлбарлалаа. “Дэлхийд түгсэн Монголын нууц товчоон” бүтээл нь Монгол түмний оюуны соёлын нандин сурвалж дэлхий дахинд хэрхэн түгснийг баримтаар харуулахаас гадна “Монголын нууц товчоон”-ы судалгааг шинэ шатанд гаргахад судалгааны чухал хэрэглэгдэхүүн болох ажээ. “Монголын нууц товчоо”-г дэлхийн 30 гаруй улс оронд азербайжан, алтай, англи, болгар, буриад, герман, испани, итали, казах, мажар, марати, монгол, орос, перс, польш, солонгос, тува, турк, уйгур, франц, халимаг, хятад, чех, эсперанто, япон зэрэг гуч шахам хэлээр орчуулж, эл сурвалж таван тивд түгэн тархсан байдаг. Тэгвэл 2016 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэмжлэгээр МУИС-ийн Монгол судлалын хүрээлэнд “Монголын нууц товчооны каталоги” сэдэвт төслийг хэрэгжүүлж, түүний үр дүнд “Дэлхийд түгсэн МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН” хэмээх энэхүү бүтээлийг хэвлүүлжээ. Уг номыг МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Монгол Улсын Үндэсний номын сан зэрэг байгууллагын эрдэмтэн судлаачид хамтран бүтээсэн байна. Номын тайлбарыг кирил, монгол бичиг, англи хэлээр бэлтгэж, зарим бүтээлийн галиг, хөрвүүлэг, орчуулгын онцлогийг тодорхой харуулах үүднээс “Монголын нууц товчоо”-ны нэгдүгээр зүйлийг үлгэр болгон хавсаргажээ. Мөн уг сурвалж бичгийн холбогдолтой марк, тэмдгийг шигтгэн оруулсан байна. Харин Монголын түүхийн цахим тайлбар толь”-ийн тухайд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилга, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэмжлэгээр Шинжлэх Ухааны Академийн Түүх, археологийн хүрээлэнгийн эрдэмтэн, судлаачдын багийн бүрэлдэхүүнтэй төслийн багийнхан сүүлийн жил гаруй хугацаанд хийж дуусгасан байна. Төслийн гүйцэтгэгч багийн ахлагчаар ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн захирал, Олон улсын Монгол судлалын Холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга, профессор С.Чулуун ажиллажээ. Тус төсөл нь агуулгын хувьд Монгол нутагт хүн үүссэн цаг үеэс эхлэн өнөөг хүртэлх 800 мянган жилийн Монголын түүхийн тулгуур гол дурсгалууд, түүхэн зүтгэлтэнүүд, түүхийн үйл явдал, үйл явцыг дотоод гадаадын эрдэмтэн судлаачдын үндсэн суурь судалгаанд үндэслэн, олон хэлний сурвалж эх хэрэглэгдэхүүн, архивын баримт, аман түүхийн мэдээлэл ашиглаж шинжлэх ухааны судалгааг үндэслэн олон нийтэд түүхийг цогцоор нь, үнэн зөв ойлголт өгөх, эх түүхийн мэдлэгийг өргөжүүлэх, түүхийн судалгааг өргөн олонд хүртээмжтэй байлгах үүднээс хийгдсэн байна. Монголын түүхийн цахим тайлбар толийг түүхийн судалгааны хамгийн сүүлийн үеийн болон хамгийн бодитой судалсан эрдэмтдийн судалгаанд үндэслэснээс гадна Монголын түүхийн аливаа асуудлыг судлахад Монголын байр суурь, Монголын судалгааны чиг хандлагыг зөв харахад томоохон түлхэц өгөх ажил болж чаджээ.

Тус тольд эхний удаад нийт 999 толгой үгийг багтаасан бөгөөд урьд өмнө ийм том хэмжээний монголын түүхийн толь бичиг Монгол Улсад ч, дэлхийн улс орнуудад ч гарч байгаагүй болно. Уг толь нь анх удаагаа орчин үеийн монгол үсгээс гадна хуучин монгол бичиг, аудио хэлбэрээр хийгдэж байгаа нь хэн бүхэнд илүү сонирхолтой болох бөгөөд хамрах хүрээг өргөжүүлсэн байна. Тус түүхийн тольд нийтдээ 2000 гаруй гэрэл зураг, түүхийн баримт, эх сурвалжийг багтаасан бөгөөд 4000 гаруй нэмж дэлгэрүүлж унших эх сурвалж, ном, өгүүлэлийн нэрсийг мөн багтаажээ. Уг төсөл нь ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнд түшиглэн тасралтгүй үргэлжлэх бөгөөд 2020 он гэхэд 5000 толгой үгийг бүтээхээр зорьж байгаа юм байна.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр -14
Шөнө -25

Нөгөөдөр
Өдөр -14
Шөнө -23

Өдрийн зурхай

**ӨВЛИЙН ДУНД ЦАГААН ХУЛГАНА САР ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ХОНЬ ӨДӨР**

**Аргын тооллын:** 2016.12.27, Мягмар гараг
**Наран ургах шингэх:** 08.41-17.06
**Үс засуулбал:** Сүлд тэнэж одно
**Барилдлага:** Түлэх
**Шүтэн барилдлага:** Авахуй



*Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эм найруулах, гэргий авах, үс авах, элч зарах, эд авахад сайн. Зүүн нүд татвал хэрүүл, тэмцэл болох, баруун нь бол эд хувцас олох, зүүн чих нь цангинавал зочин ирэх, баруун нь бол гаслан болох, нохой уливал галзуурах, хэрээ гуаглавал ураг садан эндэх, тагнай загатнавал хэн нэгний үхсэнийг сонсох, бие татвал гэнэт зочин ирэх, хөл татвал үхэл болохыг үзэх болой. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой.*

ДУУЛГАХ СОНИН

## Жүжигчин Г.Ундармаа Эрүүл мэндийн тэргүүний ажилтан боллоо

Хошин урлагийн жүжигчид дундаа хамгийн өгөөмөр нь гэгддэг жүжигчин Г.Ундармаа Хан-Уул дүүргийн эмнэлгийн хүүхдийн тасгийг тохижуулан дууcч, өчигдөр хүлээлгэн өглөө. Энэ нь түүний “Итгэлийн танхим” төрийн бус байгууллагынхаа хүрээнд хийсэн зургаа дахь ажил нь байсан юм. Тус төрийн бус байгууллага нь 40 хүүхдийн иж бүрэн 10 палат, хүлээлгийн заал, эмчийн үзлэгийн өрөө, тарианы өрөө, хүүхдийн тоглоомын өрөө, халдвар хамгааллын өрөө, эмч, ажилчдын амралтын өрөө, ариун цэврийн өрөө, хувцасны өрөөг тохижуулжээ. Үүний сацуу нарийн коридор бүхий нийт 508 м.кв газарт засвар хийж, нийт 142.8 сая төгрөг зарцуулсан байна. Хамгийн сонирхолтой нь нийт өртгийн 44 сая төгрөгийг жүжигчин Г.Ундармаа хувиасаа гаргасан бөгөөд иргэд байгууллагаас 9.4 сая төгрөг, бараа материалын 89.1 сая төгрөгийн хандив авчээ. Тэгвэл ийнхүү зургаа дахь эмнэлгээ тохижуулан



хүлээлгэн өгсөн түүний нөр их хөдөлмөрийг үнэлж нийслэлийн эрүүл мэндийн тэргүүний ажилтан медалиар шагнасан байна. Жүжигчин бүсгүйн тохижуулсан зургаа дахь эмнэлэгтэй танилцах үеэрээ Нийслэлийн гэр хорооллын хөгжил, нийгмийн асуудал хариуцсан төслийн удирдагч Ш.Анхмаа тус медалийг гардуулан өгчээ.




## Селена Гомез хүүхдийн эмнэлэгт зочилжээ

Дуучин Селена Гомез зул сарын баяраар хүүхдийн эмнэлэгт зочилж, өвчтэй хүүхдүүдэд гэнэтийн бэлэг барьжээ. Эдүгээ 24 настай дуучин бүсгүй энэ оны наймдугаар сард чонын яр хэмээх өвчнөө эмчлүүлэхээр уран бүтээлээсээ түр завсарлага авч буйгаа зарласан удаатай. Түүнээс хойш бүсгүй нөхөн сэргээх төвд өвчнөө гурван сарын хугацаанд эмчлүүлж байгаад өнгөрөгч сарын 20-ны өдрөөс дахин олон нийтийн үйл ажиллагаанд оролцож эхэлсэн байдаг. Тэгвэл Селена зул сарын баярын өмнөх өдөр буюу өнгөрөгч бямба гарагт Техас мужид байрлах “Cook Children’s Medical Center”-т зочилж, хоол хийх зэргээр өвчтэй хүүхдүүдтэй цагийг хөгжилтэй өнгөрүүлжээ. Дуучин бүсгүй гэнэт л эмнэлэгт зочилсон нь зул сарын хамгийн том бэлэг болсон гэнэ.

